

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид хүн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, цаашлаад далд эдийн засгийг ил болгож, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг бодит хэрэгцээ, шаардлагыг харгалзан хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар улсын төсөв, иргэн, хуулийн этгээдэд шинээр зардал үүсэхгүй гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хуулийн төслийн хүрээнд цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаар тэтгэвэр бодоход ямар ялгаа зааг гарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хуулийн төсөл батлагдсанаар гарах зардлын тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Засгийн газраас өргөн барихаар боловсруулж буй хуулийн төслийн үзэл баримтлал, хэзээ өргөн барихаар бэлтгэж байгаа, Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх боломжтой эсэх, нийгмийн даатгалын удирдлагын бүтэц, түүний зардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хуулийн төслийн хүрээнд иргэнд нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх эсэх сонголтыг өгч болох талаар, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоолол зөрж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун бүрэн болон хувь тэнцүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй тэтгэвэр авагчийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгчдын тоо, хуулийн төслийг баталснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ирэх ачаалал болон Засгийн газраас боловсруулж буй хуулийн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хуулийн төслийг баталснаар өндөр насны тэтгэврээс гадна нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний, амаржсаны, тэжээгчээ алдсаны, ажилгүйдлийн гэх мэт олон тэтгэмж, төлбөрүүдэд хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Төсвийн тухай хуулийн хүрээнд хуулийн төслийн хэрэгжих хугацааг дараа жилээс хэрэгжүүлэхээр зохицуулах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нийгмийн даатгалын шимтгэлийн дарамт бизнес эрхлэгчдэд хүндээр тусаж байгаа нь ирээдүйд ажил олгогч болон нийгмийн даатгалын сандаа алдагдалтай тул одооноос тодорхой зохицуулалт хийж эхлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Х.Болормаа, С.Зулпхар, О.Саранчулуун нар Засгийн газраас боловсруулж буй хуулийн төслөө шуурхай бэлтгэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Засгийн газрын харьяа байгууллагууд Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд анхаарах талаар тус тус санал хэлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Анхаарал хандуулсанд баярлалаа.

CLP

Л.ЭНХНАСАН

